

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /3/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: О.Хэрлэнзаяа
Утас: 70350757 Цахим хаяг: Kherlenzayao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

<u>1. Аудитын санал дүгнэлт</u>	2
<u>2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл</u>	5
<u>3. Аудитын тайлан</u>	9
<u>3.1 Ерөнхий зүйл</u>	12
<u>3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт</u>	13
<u>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал</u>	14
<u>3.4 Материаллаг байдал</u>	14
<u>3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга</u>	15
<u>3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв</u>	15
<u>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг</u>	15
<u>3.8 Аудитын гол асуудал</u>	16
<u>3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</u>	16
<u>3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</u>	16
<u>3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал</u>	17
<u>4. Аудитын илрүүлэлт</u>	17
<u>5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл</u>	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.03.15 № 107
танай _____-ны № _____-т

ГЭР БҮЛИЙН ОРДОН
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Б.ГАНЧИМЭГ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

2020, 2021 онуудад COVID-19 цар тахлын улмаас тус байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох хурим найр, дархан, уран бэр зэрэг үйл ажиллагааг УОК-оос зогсоосны улмаас үйл ажиллагааны орлого тасалдаж байр ашиглалтын тогтмол зардал, ажилчдын цалин хөлсөө төлж чадахгүй болж Эрдэнэт сангаас 29,785.0 мянган төгрөгийн зээл авсан байна. Зээлийн эргэн төлөлт төлөгдөөгүй, зээлийн хугацаа сунгах хүсэлтээ Эрдэнэт санруу явуулсан байна.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Аудитын гол асуудлууд

Хөл хорио тогтоосонтой холбогдуулан байгууллага орлогогүй болж ашиглалтын зардлуудын өр төлбөр үүссэн. Иймд өр төлбөрөө барагдуулах, орлого нэмэгдүүлэх зорилгоор мөн үйл ажиллагаа сурталчлах үүднээс Хөвсгөл аймгийн Мөрөн сумтай хамтран 2021 оны 03 дугаар сарын 07-ны өдөр “Дархан бэр”-34, “Уран бэр”-17 нийт 51 эзжийг тодруулах үйл ажиллагаа зохион байгуулсан.

Бусад асуудал

“Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ-т дугуйлан, сургалтад хамрагддаг бяцхан хүүхэд багачууддаа “Эрдэнэт дент” шүдний эмнэлэгтэй хамтран “Шүдээ хайралцгаая” уриатай амны хөндийн эрүүл ахуйн зөвлөгөө зөвлөмж өгч, шүдний үзлэгт хамруулсан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ нь 2021 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

COVID-19 цар тахлын улмаас Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар хөл хорио тогтоосон. Иймээс олон нийтийг хамарсан бүх үйл ажиллагаа болон түрээсийн үйл ажиллагаа зогсож орлогын эх үүсвэр алдагдсан.

Тус байгууллага нь “Залуу хос”-ын хуримнаас гадна “Алтан хурим”, “Мөнгөн хурим”, “Очир эрдэнийн хурим”-ыг зохион байгуулдаг. Цаг үеийн байдлаас хамаарч хурим найрын үйл ажиллагаа бага хийгдсэн ба нийт 20 хосын хуримыг баталсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		1-р сарын 1	12 сарын 31
1	Хөрөнгө	0	0
1.1	Эргэлтийн хөрөнгө	0	0
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	88904.92	45795.49
1.1.02	Дансны авлага	12731588.87	10247360.26
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	183545.4	183545.4
1.1.04	Бусад авлага	0	0
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	0	0
1.1.06	Бараа материал	20730498.97	24491273.25
1.1.07	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	0	0
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	0	0
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	0	0
1.1.10		0	0
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	33734538.16	34967974.4
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0	0
1.2.01	Үндсэн хөрөнгө	11757562.21	12003270.09
1.2.02	Биет бус хөрөнгө	0.04	0
1.2.03	Биологийн хөрөнгө	0	0
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0	0
1.2.05	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0	0
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	0	0
1.2.07	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0	0
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0	0
1.2.09		0	0
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11757562.25	12003270.09
1.3	Нийт хөрөнгийн дүн	45492100.41	46971244.49
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0	0
2.1	Өр төлбөр	0	0
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0	0
2.1.1.01	Дансны өглөг	33686535.33	44188911.6
2.1.1.02	Цалингийн өглөг	2412993.71	1279822
2.1.1.03	Татварын өр	8409777.03	14156120.86
2.1.1.04	НДШ-ийн өглөг	720193.27	7403844.77
2.1.1.05	Богино хугацаат зээл	0	0
2.1.1.06	Хүүний өглөг	0	0
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	0	0
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	0	0
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	0	0
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0	0
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	0	0
2.1.1.12		0	0
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	45229499.34	67028699.23
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0	0
2.1.2.01	Урт хугацаат зээл	0	0
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	0	0
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	0	0

2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	0	0
2.1.2.05		0	0
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0	0
2.2	Өр төлбөрийн нийт дүн	45229499.34	67028699.23
2.3	Эздийн өмч	0	0
2.3.01	Өмч:-төрийнн	43554506	43554506
2.3.02	- хувийн	0	0
2.3.03	- хувьцаат	0	0
2.3.04	Халаасны хувьцаа	0	0
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	0	0
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3639700	3639700
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0	0
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	4512531.8	4512531.8
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-51444136.73	-71764192.54
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0	-20320055.81
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-51444136.73	-51444136.73
2.3.10		0	0
2.3.11	Эздийн өмчийн дүн	262601.07	-20057454.74
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	45492100.41	46971244.49

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого /цэвэр/	28816854.44	49130589.72
02	Борлуулалтын өртөг	0	0
03	Нийт ашиг /алдагдал/	28816854.44	49130589.72
04	Түрээсийн орлого	21429796.3	18048430.19
05	Хүүний орлого	0	0
06	Ногдол ашгийн орлого	0	0
07	Эрхийн шимтгэлийн орлого	0	0
08	Бусад орлого	0	0
08.1	Орлогын дүн	21429796.3	18048430.19
09	Борлуулалт, маркетингийн зардал	0	0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	72724793.04	87499075.72
11	Санхүүгийн зардал	0	0
12	Бусад зардал	0	0
12.1	Зардлын дүн	72724793.04	87499075.72
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	0	0
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/ гарз/	0	0
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз/гарз/	0	0
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз/гарз/	0	0
17	Бусад ашиг/алдагдал/	0	0
17.1	Олз, гарзын дүн	0	0
18	Татвар төлөхийн өмөх ашиг /алдагдал/	-22478142.3	-20320055.81
19	Орлогын татварын зардал	0	0
20	Татварын дараах ашиг, /алдагдал/	-22478142.3	-20320055.81

21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/	0	0
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-22478142.3	-20320055.81
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0	0
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0	0
23.3	Бусад олз/ гарз/	0	0
24	Орлогын нийт дүн	0	0
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/	0	0

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2019 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	43554506	3639700	4448532	-28965994.43	22676743.4
02	НББ-ын бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0	0
03	Залруулсан үлдэгдэл	43554506	3639700	4448532	-28965994.43	22676743.4
04	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	0	0	0	-22478142.3	-
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0
06	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	64000	0	64000
07	Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0
09	2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	43554506	3639700	4512532	-51444136.73	262601.07
10	НББ-ын бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0	0
11	Залруулсан үлдэгдэл	43554506	3639700	4512532	-51444136.73	262601.07
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	0	0	0	-20320055.81	-
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0
14	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0	0
15	Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0
17	2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	43554506	3639700	4512532	-71764192.54	-

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дүн	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	72034690	73124719
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	31306540	22277600
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0	0

1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0	0
1.1.4	Буцаан авсан албан татвар	0	0
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0	0
1.1.6	Бусад мөнгөн орлого	40728150	50847119
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	72363888.79	73167828.43
1.2.1	Ажиллагчдад төлсөн	32368065.44	45401342.04
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8664255.26	4786628.96
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	5464728	15215978
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	14206135.02	1246229.43
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0	0
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0	0
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	6830405.07	203800
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0	0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	4830300	6313850
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	329198.79	43109.43
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	0
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0	0
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0	0
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0	0
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0	0
2.1.8	Бусад	0	0
2.2	Мөнгөн зэрлэгийн дүн (-)	0	0
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0	0
2.2.6	Бусад	0	0
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	0
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	0
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0	0
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас	0	0
3.1.3	Төрөл бүрийн хандив	0	0
3.1.4	Бусад	0	0
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0	0
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0	0
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0	0
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0	0

3.2.4	Төлсөн ногдол ашиг	0	0
3.2.5	Бусад	0	0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	0
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	329198.79	43109.43
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	418103.71	88904.92
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	88904.92	45795.49

2.5 Аудит хийсэн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө

Гэр бүлийн ордоны ашиг алдагдлын тооцоо		
№	Үзүүлэлт	
1	Борлуулалтын орлого	79,712,280.26
2	Нийт зардал	79,612,337.18
3	Татвар ногдох орлого	99,943.08
4	Татвар 10%	9,994.31
5	Цэвэр ашиг	89,948.77
6	Шаардлагатай хөрөнгө оруулалт	0
7	Тайлант үеийн ашиг	89,948.77

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 02-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Хэрлэнзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

“Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ-ийн 2021 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 7-ны өдрийн 7 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

“Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ-нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 67,179.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцож 1,007.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 705.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлаггүй гэж үзлээ.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ-ийн зорилго нь төлөв төвшин бат бэх, насан туршид ханилан, үлгэр жишээ болох гэр бүлийг батламжилж, амьдралын зөв хэв маягийг цогцлоон бүрдүүлж, өрхийн боловсролыг удмаас удамд өвлүүлэн үлдээхэд хувь нэмрээ оруулахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг гэрлэх ёслолын зан үйлийн үйлчилгээ, гэр бүлийн хөгжлийн сургалт сурталчилгаа, хурим болон гоёлын хувцас, эд хэрэглэлийн поркатиин үйлчилгээ явуулах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит ААТҮГ гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ нь Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2006 оны 10 сарын 10-ний 86 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 5-д “Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавина” гэсэн заалттай нийцэж байна. Тус байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Дотоод зохион байгуулалтын хүрээнд зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг тайлант онд гаргаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулж ажиллах арга хэмжээ авсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өөрчлөлт орсон.
- ТБОНӨХБАҮХАТХууль 2021 онд өөрчлөлт орсон.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
----------	----------------	-----------------	----------

Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	88.9	45.7	-43.1
УХХО	0	0	0
Авлага	12,915.1	10,430.9	-2,484.2
Бараа материал	20,730.4	24,491.2	3,760.7
Үндсэн хөрөнгө	11,757.5	12,003.2	245.7
Нийт хөрөнгийн дүн	45,492.1	46,971.2	1,479.1
Өр төлбөрийн дүн	45,229.4	67,028.6	21,799.1
Богино хугацаат өглөг	0	0	0
Эздийн өмч	262.7	-20,057.4	19,794.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	45,492.1	46,971.2	1,479.1

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 34.9 мянган төгрөг, банкны харилцах дансанд байгаа 10.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Түрээсийн авлагын үлдэгдэл 10,430.9 мянган төгрөг болж 2,484.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 24,491.2 мянган төгрөг болж 3,760.8 мянган төгрөгөөр өссөн нь шинээр бараа материал худалдан авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 67,028.6 мянган төгрөгийн өр үүссэн байна. 2020, 2021 онуудад COVID-19 цар тахлын улмаас тус байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох хурим найр, дархан уран бэр зэрэг үйл ажиллагааг УОК-оос хаасан, мөн өмнөх онуудаас хуримтлагдан ирсэн өр төлбөр зэрэг шалтгаанаас үүссэн 76,319.4 мянган төгрөгийн өр төлбөрөөс 9,290.7 мянган төгрөгийн өр төлбөр төлөгдөн, 67,028.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь COVID-19 цар тахлын улмаас уг байгууллагын үйл ажиллагаа зогсонги байдалд орж, байр ашиглалт, татвар, НД-ийн өр төлбөрүүд тогтмол гарч байсан тул тус байгууллагын өр төлбөр нэмэгдэхэд шалтгаалсан, энэ нь уг байгууллагыг алдагдалтай ажиллахад мөн өр төлбөр нэмэгдэх, цаашлаад санхүүгийн хүнд байдалд хүргэх үр дагавартай байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 79,712.2 мянган төгрөгөөр, нийт урсгал зардлыг 79,512.3 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 0.00 мянган төгрөг байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлого 49,130.5 мянган төгрөг, түрээсийн орлого 18,048.4 мянган төгрөг, нийт 67,179.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, Эрдэнэт сангаас 29,785.0 мянган төгрөгийн зээл авч эргэн төлөлт огт хийгдээгүй байна. Тайлант онд 87,499.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас, 173 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ” гэсэн заалтын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Өмнөх оны аудитаар илэрсэн алдаа зөрчилтэй асуудлын хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан. Бараа материалын зардалтай холбоотой асуудлаар 1 зөвлөмж, балансын данстай холбоотой асуудлаар 1 зөвлөмж, НББ-ын бодлоготой холбоотой асуудлаар 1 зөвлөмж өгсөн. Зөвлөмжийг 70 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэж болох юм.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 190.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 124.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 66.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

8.1 Залруулсан алдаа: Аудитын явцад залруулсан алдаа байхгүй болно.

8.2 Зөвлөмж

1. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын удирдлага өөрөө өөртөө томилолт өгч 66.0 мянган төгрөгийн томилолтын зардал авсан байна.

Энэ нь нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.2.-д "хувийн ашиг сонирхол" гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг гэж заасантай холбогдон өөрөө өөртөө давуу байдал олгосон байж болзошгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харъяалах дээд шатны удирдлагын шийдвэрийн дагуу томилолт олгож байх.

8.3 Төлбөрийн актИлрүүлэлт:

Байгууллагын хөрөнгөөр 124.7 мянган төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авсан байна.

Энэ нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7.9.-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Дээрх зөвлөмж, төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ	2	190.7	0	0	1	124.7			1	66.0



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 60/60 АН-2022/3/НА-СТА-ОНӨААН Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын хөрөнгөөр 124,700 төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авсан байна.

Энэ нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7.9-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгууллагын хөрөнгөөр архи, согтууруулах ундаа худалдан авсан 124,700 төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ-ын дарга Б.Ганчимэг, нягтлан бодогч Ж.Оюунномин нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР.....Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР.....Б.ЭРДЭНЭ

АУДИТОР.....О.ХЭРЛЭНЗАЯА

